



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/417

Булган сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зохих зөвшөөрөлгүй болон ус ашигласны төлбөрөө төлдөггүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг шалгах, зөрчлийг арилгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Жаргалсайхан (аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: Т.Наранцацралт (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч)
Г.Баяржаргал (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Биологийн төрөл зүйл, сургалт сурталчилгаа, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн)
М.Одбаяр (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)
С.Санжаасүрэн (Татварын хэлтсийн Хяналт шалгалтын тасгийн дарга)

2.Шалгалтын ажиллагааг зохион байгуулж, дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Д.Жаргалсайхан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ